

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Гүйцэтгэсэн:

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хуулийн мэргэжилтэн-
зөвлөх Б.Баяндүүрэн

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай”¹ үзэл баримтлалыг 1995 онд баталж, үүнээс хойш чөлөөт бүсүүдийн эрх зүйн байдлыг зохицуулсан бие даасан дөрвөн² хуулийг Монгол Улсын Их хурал 2002-2003 онд тус тус батлан мөрдүүлж байсан бөгөөд 2015 онд Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсийн тухай хуулиудыг хүчингүй болгож, Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн найруулж Чөлөөт бүсийн тухай нэг хууль батлан өнөөг хүртэл мөрдүүлж ирсэн.

Чөлөөт бүсийн тухай хууль нь чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

“Чөлөөт бүс” гэдэгт гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгох ба чөлөөт бүс байгуулах зорилго нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх юм.

Монгол Улсад одоогийн байдлаар Цагааннуур, Алтанбулаг болон Замын-Үүд боомтууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хамгийн сүүлд УИХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх "Чингис хаан" Олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийг байгуулсан.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг АХБ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хуулийн мэргэжилтэн-зөвлөх гүйцэтгэснийг танилцуулж байна.

¹ Монгол Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоол

² Алтанбулаг чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль 2002 он, Чөлөөт бүсийн тухай хууль 2002 он, Замын-Үүд чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль 2003 он, Цагааннуур чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль 2003 он.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Чөлөөт бүсийн тухай хууль /цаашид “ЧБТХ” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “Аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар гүйцэтгэсэн болно.

Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох:

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг 1995 онд баталж, үүнээс хойш чөлөөт бүсүүдийн эрх зүйн байдлыг зохицуулсан бие даасан дөрвөн хуулийг Монгол Улсын Их хурал 2002-2003 онд тус тус батлан мөрдүүлж байсан бөгөөд 2015 онд Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсийн тухай хуулиудыг хүчингүй болгож, Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн найруулж Чөлөөт бүсийн тухай нэг хууль батлан өнөөг хүртэл мөрдөж ирсэн.

Уг хуульд 2015, 2016, 2017, 2019 онуудад тус бүр 1 удаа, 2021 онд 2, 2022 онд 3 удаа, 2024 онд 2 удаа нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ба эдгээр өөрчлөлтүүд нь Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль, Төр, хувийн хэвшлийн тухай хууль, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон болон шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой байсан бол нэг удаагийн өөрчлөлт нь эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн талаарх зохицуулалтыг оруулахад чиглэжээ.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг тус улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүс, болон эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдэд ижил тэгш хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэн энэхүү судалгааг гүйцэтгэв.

Үнэлгээ хийх хүрээг тогтоох:

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /эерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа бөгөөд эдгээрийг хэр оновчтой сонгохоос судалгааны чанар ихээхэн хамаарах ба хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд заалтуудыг түүвэрлэн сонгож тухайн заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг цуглуулж, нэгтгэх, шинжлэн дүгнэх шаардлагатай гэж үзсэн болно.

Судалгааны эхний үе төлөвлөх шатанд хуулийн бүх заалтыг хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээллийг Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүс, Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсээс цуглуулан авч, уг мэдээллийг нэгтгэн дүгнэж,

зохицуулалтын хувьд дутагдал, доголдолтой заалтыг өөрчлөх, шинэчлэхэд шаардлагатай судалгааны ажлыг хийх нь оновчтой гэж үзлээ.

Мөн цуглуулсан мэдээллээ үнэн зөв эсэхийг батлах зорилгоор дээрх чөлөөт бүсүүдийн холбогдох албан тушаалтнуудтай экспертийн ярилцлага хийж баталгаажуулсан болно. Тухайлбал, Цагааннуур чөлөөт бүсийн ахирагчийн ажлын албаны дарга Ц.Итгэл, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ш.Арай, Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Х.Жанболат, Газрын бүртгэл, газар зохион байгуулагч О.Нургүл, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагч Б.Азжаргал, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Мядагсүрэн, Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Х.Зоригт, Т.Өлзийбаяр, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Цэрэнбадам болон Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Ш.Амартүвшин, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Чулуун-Эрдэнэ, Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Ономаа, Гэрээ эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баттулга, Б.Доржханд, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга М.Амгалан, мэдээллийн технологийн ажилтан Ц.Нармандах нартай уулзаж, экспертын ярилцлага болно.

Чөлөөт бүсийн үүсэл гарлын хувьд дээр дурдсанчлан Монгол Улсын Их Хурлын 1995 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг баталсан.

Улмаар Монгол улсын Их Хурал 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Чөлөөт бүсийн тухай хууль, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай хууль, 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд баталсан хэрэгжүүлж байгаад 2015 онд Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлагдснаар тус тусдаа байсан чөлөөт бүсийн хуулиудыг хүчингүй болгосон.

Мөн чөлөөт бүсийн тухай хуулиас гадна гаалийн тухай хууль, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцийн зарим холбогдох заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горимыг хэрэгжүүлэх журам” зэрэг хэм хэмжээгээр чөлөөт бүстэй холбогдох харилцааг зохицуулж байна. Чөлөөт бүсийг амжилттай явуулахад тодорхой нөхцөл бүрдсэн байх шаардлагатай гэж үздэг байна.

Чөлөөт бүс тус бүрийн онцлогт тохирсон бие даасан хуулиуд батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын Их хурлын 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт Монгол Улсын Их Хурлын 1996 оны 66 дугаар тогтоолоор хилийн заагийг тогтоосон 500 га газарт "Алтан булаг" чөлөөт бүсийг, Монгол Улсын Их хурлын 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн нутагт Замын-Үүд боомтыг түшиглэн 900 га газарт "Замын-Үүд" чөлөөт бүсийг, Монгол Улсын Их хурлын 2005 оны 12 дугаар сарын

01-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт 708.4 га газарт "Цагааннуур" чөлөөт бүсийг, сүүлд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн суманд 1000 га газарт "Чингис хаан" Олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийг байгуулсан байна.

Мөн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүлэмж-агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр "Агро-сити", Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийг тус тус байгуулахаар Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаас шийдвэрлэсэн ба "Агро-сити" эдийн засгийн тусгай бүс нь хүнсний аюулгүй байдлыг хангах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүс нь олон улсын тээвэр ложистик, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлэхээр төлөвлөжээ.

Энэ нь УИХ-аас 2021 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2023 онд нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн тухай байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь нийслэл хотын төвлөрлийг бууруулах, нэг төвт хотоос олон төвт хот болон хөгжих хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлсэн билээ. Үүнтэй холбогдуулан УИХ-аас баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулагдаж байгаа ба дээрх 2 эдийн засгийн тусгай бүс байгуулах ажил, арга хэмжээ нь "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-д тусгагдсан байна.

Чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс байгуулах зорилгыг тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино гэж заасан бөгөөд тухайн чөлөөт бүсийн байгуулагдсан зорилгыг УИХ-ын тогтоолд тусгалгүй, зөвхөн хилийн цэсийг тогтоож өгсөн байна.

Гэхдээ Чөлөөт бүсийн тухай хуульд чөлөөт бүс хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байхаар тогтоож, энэ төлөвлөгөөг Засгийн газар батлахаар хуульчилжээ. Гэвч Засгийн газрын 2011 оны тогтоолоор "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг, 2025 оны тогтоолоор Цагааннуур чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг тус

тус баталж, Алтанбулаг болон хөшигийн хөндий дэх чөлөөт бүс, Сонгинохайрхан, Налайх дүүрэг дэх эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байна.

Чөлөөт бүсийг байгуулснаар экспортын үйлдвэрлэлийг урамшуулсны үндсэн дээр валютын эх үүсвэртэй болох, ажлын байр нэмэгдэх, үндэсний аж ахуйн өсөлтийг нэмэгдүүлэх, гааль, татвар, хөрөнгө оруулалтын тогтолцоо нь гадаад ба дотоодын хөрөнгө оруулагчдад хамгийн тааламжтай нөхцлийг бий болгодог гэж үздэг ба тухайн бүсэд ажлын байр нэмэгдэж, амжиргааны түвшин дээшлэх, гадаад шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх зэрэг эерэг үр дагаварууд илэрдэг ч Засгийн оролцоо шаарддагаас үүдэж улс төрийн нөлөө орох, төрийн бодлого тогтворгүйгээс үүдэж хөрөнгө оруулагч буурах, эхний жилүүдэд бизнесийн таатай орчин бүрдэж орлого орох нь тодорхойгүй байх зэрэг эрсдлүүд тулгардаг.

Улс бүр өөрийн нөөц боломж, онцлог дээрээ тулгуурлан чөлөөт бүсийн төрлөө сонгодог бөгөөд чөлөөт бүсийг байгуулснаар нэн тэргүүнд тухайн бүсэд бизнес эрхлэгч ашигтай ажиллах, иргэд ажлын байртай болох нь чухал асуудал юм. Ингэснээр улсын экспортын барааны нэр төрөл нэмэгдэх, үндэсний үйлдвэрлэгч хөгжих боломж бүрдэх юм. Чөлөөт бүсийг байгуулахад төрөөс бизнесийг дэмжих зорилгоор нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнд суурилсан байх, чөлөөт бүс байрлах бүс нутагт авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийг хөгжүүлэх боломжтой байх, чөлөөт бүсэд ашиглах усны нөөц, эрчим хүчний хангамжтай байх, хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлийг хангасан байх, чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллага итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин, нөхцөл бий болгох, байгаль орчинд ээлтэй байх, бүс нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилтныг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх зарчим, нөхцлийг баримталж амжилтад хүрдэг.

Манай улсын хувьд үе үеийн Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрт чөлөөт бүс, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, экспортыг дэмжих, үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ажил, арга хэмжээнүүдийг тусгаж ирсэн байдаг. Тухайлбал:

-Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур зэрэг суурин газруудад эхэлсэн эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ”, “Эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк хөгжүүлэхэд дэд бүтэц, эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх замаар дэмжлэг үзүүлнэ.” гэж;

-Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ““Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах”;

-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана”;

-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана”, “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна”;

-Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аялал жуулчлал, тээвэр, логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Хүннү дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна”, “Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан “Цахиурын хөндий”, дата төв, хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ”, “Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв байгуулна”, “Орон нутагт чөлөөт бүс, тусгай бүс, аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно”, “Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийг бүрэн ашиглалтад оруулна”, “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ”, “Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ”, “Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ”, “Чөлөөт бүсүүдэд бизнес инкубатор төвийг байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ” гэж тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулсан байна”, “Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлсэн байна”, Улаанбаатар бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна” гэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ”, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт

бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ”, “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна”, “Хөшигийн хөндий, Говьсүмбэрийн Баянталд эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулна”, “Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсийг барьж дуусгана” гэсэн арга хэмжээг тусгасан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ”, “Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна” гэж тусган энэхүү шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хилийн зарим боомтыг нэмж чөлөөт бүс болгон хөгжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх” гэх мэтээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг үе шатыг тодорхойлж өгсөн байна.

Дээрх бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаанууд нь Монгол Улсын төр, засгийн газрын чөлөөт бүсийн үйл ажиллагааг өргөжүүлэх, улс орны эдийн засагт өсөлт авчрахад чиглэж, бодлого, үйл ажиллагаа тогтвортой мэт харагдаж байгаа ч хэрэгжилт төдийлөн хангалтгүй байна.

Хэрэгжилт хангалтгүй байгааг уг асуудлыг хариуцаж, хэрэгжүүлж буй тогтолцооны тогтвортой байдлаас хамааралтай гэж тайлбарлаж болохоор байна. Тухайлбал, Чөлөөт бүсийн хөгжлийн асуудал нь 2003-2008 онд Үйлдвэр худалдааны сайдын, 2008-2012 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайдын, 2012-2014 онд Монгол Улсын Шадар сайдын болон Эдийн засгийн хөгжлийн сайдын, 2014-2016 онд Аж үйлдвэрийн сайдын, 2016 оны дунд үеэс Монгол Улсын Шадар сайдын, 2021 оны 11 дүгээр сараас Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байсан ба 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарч байгаагаас харж болох юм.

Чөлөөт бүсийг байгуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт, тогтвортой хэрэгжих төрийн зөв бодлого, оролцоо маш чухал үүрэгтэй юм. Эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх засгийн газрын үүргээ гүйцэтгэх байдлаас хамаарч хөгжлийн тулгуур болох бизнесийн оролцоог хангах явдал төрийн бодлогоос шалтгаалдаг. Тийм ч учраас тухайн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд, иргэнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон гаалийн хялбарчилсан горимыг санал болгодог. Тухайлбал чөлөөт бүсийн тухай хуулийг 2015 онд шинэчлэн найруулахдаа эрх зүйн орчныг таатай болгох, зорилгоор зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй байхаар, барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс

хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр, чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцохоор зохицуулсан. Мөн чөлөөт бүсэд татварын цөөнгүй хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхээр тусгасан нь ололтой боловч эрх зүйн зохицуулалтыг үр нөлөөг дүгнэх боломж хараахан үүсээгүй байна.

Өөрөөр хэлбэл чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, үйл ажиллагаа явуулахаар газар эзэмших, ашиглах гэрчилгээ авсан, төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдүүд ажлаа эхлүүлээгүй, чөлөөт бүсийн механизм бүрэн утгаараа ажиллаагүй болохоор үр нөлөөг дүгнэхэд өрөөсгөл байна. Энэ чөлөөт бүсийн үйл ажиллагаа хэвийн хуулийн хийдэл үүсээгүй мэт харагдуулж байна гэсэн үг.

Судалгааны явцад Чөлөөт бүсийн тухай хуулиас сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжснээс хойш буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав. Мөн судалгаанд дурдсан тоо баримт, дэвшүүлсэн санал зэргийг батлах үүднээс тохиолдол судлах аргыг ашиглан бусад улсад хэрхэн хэрэгжиж буй байдлыг авч үзэх нь тохиромжтой байна.

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно. Хоёрдогч эх сурвалжаар холбогдох хууль тогтоомж, онолын үндэслэлийг тухайн сэдвээр гаргасан ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэмтэн судлаачдын нийтлэл, гарын авлагыг үнэлгээний ажилдаа ашигласан болно. Тухайлбал,

Үнэлгээнд анхдагч эх сурвалжаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтууд, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл болон Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүс, Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсээс авсан Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, тэдгээрийн ажилтан, албан хаагчидтай хийсэн экспертийн ярилцлагаар авсан мэдээллийг ашигласан.

Харин хоёрдогч эх сурвалжийн хувьд ДБ, АХБ-аас гаргасан чөлөөт бүсийн талаарх судалгааны тайлан, дэлхийн бусад орнуудын эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуулиудад хийсэн харьцуулсан шинжилгээ болон судлаач Ц.Норовдондог, Р.Батсүх, Б.Буяндэлгэр, Ц.Түвшинзаяа, Д.Золбоо, Д.Жигваагүнсэл нарын хамтарсан “Монгол Улсын чөлөөт бүс, бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарах бичил бүс тогтоох судалгаа бусад орны туршлага”, Отгонтэнгэр Их сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш О.Хишигмөнхийг “Монгол Улсын чөлөөт

бүсийн хөгжилд тулгамдсан зарим асуудал”, ШҮТИС-ийн оюутан Б.Гэрэлжаргалын “Монгол Улсын чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь”, Санхүү, эдийн засгийн их сургуулийн энх зүйн тэнхимийн оюутан Д.Алтангэрэлийн “Монгол Улс дахь эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын асуудал: Замын-Үүд чөлөөт бүсийн жишээн дээр” сэдэвт эрх зүйн бакалаврын зэрэг горилсон дипломын төсөл, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, профессор, эдийн засгийн ухааны доктор (Sc.D) Ц.Баатарын “Монгол, Хятад, Оросын хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж, сорилт” өгүүлэл, Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн багш Н.Отгонсайханы “Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан хил дамнасан чөлөөт бүс байгуулах урьдчилсан нөхцөл, боломж” зэрэг судалгааны ажлуудтай танилцаж дүгнэлт, зөвлөмжийг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

Зүйл, хэсэг	Хэрэгжилт	Эх сурвалж
<p>6 дугаар зүйл.Чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний хилийн цэс, байршлыг тогтоох, үйл ажиллагааг нээх, түр хаах</p> <p><u>/Энэ зүйлийн гарчигт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p>	<p>Чөлөөт бүс тус бүрийн онцлогт тохирсон бие даасан хуулиуд батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутагт Монгол Улсын Их Хурлын 1996 оны 66 дугаар тогтоолоор хилийн заагийг тогтоосон 500 га газарт "Алтан булаг" чөлөөт бүсийг, 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн нутагт Замын-Үүд боомтыг түшиглэн 900 га газарт "Замын-Үүд" чөлөөт бүсийг, 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт 708.4 га газарт "Цагааннуур" чөлөөт бүсийг, сүүлд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн суманд 1000 га газарт "Чингис хаан" Олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн "Хөшигийн</p>	

	<p>хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийг байгуулсан байна.</p> <p>Чөлөөт бүс байгуулах асуудлыг хуульд заасны дагуу Засгийн өргөн мэдүүлснээр байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоон Улсын Их Хурал шийдвэрлэж ирсэн байна.</p> <p>Мөн Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2019 онд байгуулж, хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурал 2021 онд соёрхон баталсан байна.</p> <p>Засгийн газрын 2021 оны 223 дугаар тогтоолоор "Замын-Үүд" чөлөөт бүсийг 2021 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн гүний гарцаар зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг чөлөөт бүсэд нэвтрүүлэх байнгын ажиллагаанд, Засгийн газрын 2022 оны "Цагааннуур" чөлөөт бүсийг 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг чөлөөт бүсэд нэвтрүүлэх байнгын ажиллагаанд тус тус шилжүүлсэн бол Засгийн газрын 2014 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсэд зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх түр журмыг зохицуулалтаар нээснээс өөр эрх зүйн актаар үйл ажиллагааг нээгээгүй эсвэл үйл ажиллагааг нээсэн Засгийн газрын тогтоолыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгээгүй байна.</p>	
<p>7 дугаар зүйл.Чөлөөт бүсийн эрхэлсэн газрын бүрэн эрх</p>	<p>Чөлөөт бүсийн хөгжлийн асуудал нь 2003-2008 онд Үйлдвэр худалдааны сайдын, 2008-2012 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайдын, 2012-2014 онд Монгол Улсын Шадар сайдын болон Эдийн засгийн хөгжлийн сайдын, 2014-2016 онд Аж үйлдвэрийн сайдын, 2016 оны дунд үеэс Монгол Улсын Шадар</p>	

	<p>сайдын, 2021 оны 11 дүгээр сараас Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байсан ба 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарч байна.</p> <p>Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах талаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах, үйл ажиллагаагаа жил бүр Засгийн газарт тайлагнаж, чөлөөт бүс дэх төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чөлөөт бүсийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах, чөлөөт бүсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах, чөлөөт бүсийн талаарх төрийн зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой төсвийг боловсруулах, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах, чөлөөт бүсэд зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийг удирдлагаар хангаж, хэрэгжилтийг хангуулах, чөлөөт бүсийн хөгжлийн төсөл болон чөлөөт бүсийн талаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд заасан байна.</p>	
<p>8 дугаар зүйл.Чөлөөт бүсийн захирагч, түүний бүрэн эрх</p>	<p>Чөлөөт бүсийн Захирагчийг нь чөлөөт бүсэд төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч гэж тодорхойлоод түүнийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилогдож, чөлөөлөгдөхөөр хуулийн зохицуулалттай бөгөөд үйл ажиллагаагаа Ажлын албаны бүтэцтэйгээр хэрэгжүүлж, чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний өмнө ажлаа хариуцаж байна.</p>	

	<p>Захирагч нь бүрэн эрхийнхээ хүрээнд чөлөөт бүсийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх, чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар чөлөөт бүсийг төлөөлөх, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах, чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах зөвшөөрөл олгох, чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p>	
<p>9 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн зохицуулалт</p>	<p>Чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад тусгай дэглэм үйлчилнэ гэж хуульчилсан ба дээрх тусгай дэглэмийг хэрэгжүүлэхдээ тухайн асуудал хариуцсан байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах талаар зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.</p> <p>Тухайлбал, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүдэд зорчигч, тээврийн хэрэгсэл нэвтэрсэн тохиолдолд харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа хилийн эсвэл дотоодын цэргийн байгууллага бүртгэж, бүртгэлийн мэдээллийг гаалийн болон гадаадын иргэн, харьяатын байгууллагад цахимаар солилцох, солилцсон мэдээлэлдээ үндсэн тайлан мэдээллээр чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнийг хангах зохицуулалт бүхий журмыг батлуулж хэрэгжүүлэх.</p>	

<p>10 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх гаалийн тусгай дэглэм</p>	<p>Барааг чөлөөт бүсэд нэвтрүүлэхдээ Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 7.6.5-д заасны дагуу чөлөөт бүсийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж байна.</p> <p>Энэхүү үйл ажиллагаанд Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам” ашиглаж байна.</p> <p>Мөн хуулийн энэ заалтын дагуу чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулсан зорчигчийн хувийн эд зүйлсээс бусад, худалдаж авсан 3.0 хүртэлх сая төгрөгийн үнийн дүнтэй барааг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлж, үүнээс илүү гарсан тохиолдолд гаалийн болон холбогдох татварыг ногдуулж байна.</p>	
<p>11 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх визийн тусгай дэглэм</p>	<p>Чөлөөт бүс дэх визийн дэглэм энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжиж байна.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаагаа явуулж байгаа Алтанбулаг, Замын-Үүд чөлөөт бүсүүд нь хил хамгаалах байгууллагын хамгаалалтад, харин Цагааннуур чөлөөт бүс нь нутгийн гүнд байрлалтай тул Засгийн газрын тогтоолын дагуу дотоод цэргийн хамгаалалтад байж чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, Тээврийн хэрэгслийн бүртгэлийг хамгаалалт гүйцэтгэж байгаа байгууллагууд гүйцэтгэж байна.</p> <p>Жилд дундажаар чөлөөт бүсээр нийт зорчигч, тээврийн хэрэгсэл зорчиж, тэдгээрийн ... хувь нь гадаадын иргэн харьяалалгүй хүн байна.</p>	
<p>12 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн зохицуулалт</p>	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, “Алтанбулаг” чөлөөт бүс, “Замын-Үүд” чөлөөт бүс, “Цагааннуур” чөлөөт бүсийн захирагчийн хамтарсан 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/72; А/56; 33 тоот тушаал, захирамжийн дагуу “Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх тусгай журам”-д заасны дагуу чөлөөт бүсэд бүртгэлтэй</p>	

	<p>ААН-үүдийн хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэж байна.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар Цагааннуур чөлөөт бүсэд 67 хуулийн этгээд бүртгэлтэйгээс 3 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Алтанбулаг чөлөөт бүсэд 129 бүртгэлтэйгээс 10 хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна.</p> <p>Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд 81 хуулийн этгээд бүртгэлтэйгээс 8 хуулийн этгээд үйл ажиллагаа нь тогтмолжсон ажиллаж байна.</p>	
13 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт	Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэж байна.	
14 дүгээр зүйл.Чөлөөт бүс дэх хяналтын зохицуулалт	Одоогоор гаалийн хяналтын явцад мал, амьтан, ургамал, хорио цээртэй холбоотой зайлшгүй шалгах шаардлагыг гаалийн хяналтын улсын байцаагч Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 зугаартай тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын дагуу гүйцэтгэж байна.	
15 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм	<p>Чөлөөт бүс үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хугацаанд чөлөөт бүсүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд гадаадын иргэн, харъяалалгүй хүн бүртгэгдэж, хөдөлмөрийн харилцаа үүсгээгүй байна.</p> <p>Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.</p>	
16 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх татварын тусгай дэглэм	"Хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж	

	<p>гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгох</p> <p>монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад нэмэгдсэн өртгийн албан татварыг ""0"" хувь хэмжээгээр ногдуулах;</p> <p>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх</p> <p>Барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулах</p> <p>Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй</p> <p>Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй"</p>	
<p>17 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх тусгай дэглэмийн болон бусад үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх</p>	<p>Үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт бүсүүдэд тусгай дэглэмийн зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ тухайн хариуцагч байгууллагууд /Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжийн хяналтын ерөнхий газар/-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.</p>	
<p>18 дугаар зүйл.Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны төрөл</p>	<p>Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар Засгийн газраас чөлөөт бүс байгуулах байршил, цэгийн мэдээллийг Монгол Улсын Их Хуралд оруулж, шийдвэрлүүлдэг.</p> <p>Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот</p>	

	тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор хуульчилсан өнөөдрийн байдлаар чөлөөт бүсүүд нутаг дэвсгэрийн онцлог, байршил, хэтийн зорилго зэргээс хамааран ерөнхий төлөвлөгөө, түүний төсөлдөө худалдаа үйлчилгээ, тээвэр логистик, амралт зугаалга, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар ерөнхий төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	
19 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлого	Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж, чөлөөт бүсийн төрийн өмчийн барилга байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр, газрын төлбөр, бусад аж ахуйн ажил, үйлчилгээний орлогыг төвлөрүүлэхээр хуульд тусгагдсан. Цагааннуур чөлөөт бүсийн алба хаагчидтай уулзаж, ярилцлага хийх үед энэ хуулийн 19.1.1 дэх заалтыг Татварын байгууллагын эрхлэх асуудалд хамаарах тул Захирагчийн ажлын алба уг орлогын албан татварыг төвлөрүүлэх боломжгүй талаар санал хэлж байсан болно.	

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Чөлөөт бүсийн тухай 2015 оны хуулийн “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхдээ аргачлалын дагуу хууль батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг шалган хууль бүхэлдээ зорилго, зорилтдоо нийцсэн эсэхийг үнэлэх юм.

Иймд Чөлөөт бүсийн тухай хуульд оруулсан 12 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Төр, хувийн хэвшлийн тухай хууль, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон болон шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой байсан бол нэг удаагийн өөрчлөлт нь эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн талаарх зохицуулалтыг шинээр нэмж, өөрчлөлт оруулсан байна.

ДҮГНЭЛТ

1. Зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалтай харьцуулсан судалгааг нарийвчлан тодорхой үйл ажиллагаа процесст чиглүүлэн чөлөөт бүсийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулдаг, хяналт тавих эрх бүхий төвлөрсөн төрийн захиргааны байгууллагатай болох шаардлагатай байна.
2. чөлөөт бүсэд ажиллах журмын талаар зохицуулалтыг нарийвчлан шинээр нэмэх, тухайлбал, Чөлөөт бүсийн тухай хуульд журмын агуулгын талаар тусгаж, журам баталж хэрэгжилтийг хангах асуудлыг чөлөөт бүсийн Захирагчид эсвэл чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд эрх олгох шаардлагатай байна;
3. Чөлөөт бүсэд нэвтрэлтийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд боловсруулсан “Чөлөөт бүсийн үйл ажиллагааны мэдээллийн сан, түүнийг ашиглах, мэдээлэл солилцох” журмын зохицуулалтыг хуульд шинээр нэмэх, тухайлбал, журмыг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах эрх олгох шаардлагатай байна;
4. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрхийг Засгийн газрын зөвшөөрлөөр чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эсвэл чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулж болох зохицуулалтыг шинээр тусгах зэрэг саналтай байна.

---oOo---